



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2019 оны 03 сарын 28 өдөр

Дугаар A/38

Ховд

┌ Эд хөрөнгийн тооллогын комисс ┐  
байгуулах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-ын 11.2.1, 11.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 126 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн нөөцийн газрын эд хөрөнгөнд тооллого хийх комиссыг дараахь бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Н.Ганзориг	-Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Энхбаатар	-Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Эрдэнэбат	-Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Мөнгөнцоож	-Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер

Нарийн бичгийн

дарга:	С.Мөнх-Очир	-Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн
--------	-------------	--

2.Аймгийн нөөцийн газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө /бараа материал/-ийн тооллогыг 2019 оны 04 дүгээр сарын 01-05-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтоосугай.

3.Тооллогын бэлтгэл ажлыг зохих журмын дагуу бүрэн хангаж, тооллогын комиссын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/, тооллогыг тогтоосон хугацаанд холбогдох ажил хариуцсан ажилтнуудыг байлцуулан зохих журмын дагуу үнэн зөв, чанартай явуулж дуусгахыг тооллогын комиссын дарга /Н.Ганзориг/ нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тооллогын дүнгээр эд хариуцагч няравын тооцоог бодож, дүнг 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдөрт багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/, тооллогын комиссын дарга /Н.Ганзориг/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД